



МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2024 ОНЫ УРЬДЧИЛСАН ГҮЙЦЭТГЭЛ

Монгол Улсын Их Хурлын <http://parliament.mn/c/pwyo>
цахим хаягаар, эсхүл дараах QR кодыг ашиглан бусад
танилцуулга, мэдээтэй танилцана уу.



УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

2024 он | №12

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл: 735.1 тэрбум төгрөгийн алдагдалтай гарчээ. 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл өмнөх оны мөн үеэс 1,521.0 тэрбум төгрөгөөр буурсан бол төлөвлөсөн дүнгээс 2,126.2 тэрбум төгрөгөөр сайжирсан байна.

Төсвийн орлогын хувьд: 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 29,589.2 тэрбум төгрөгт болж, орлогын төлөвлөгөө 1,122.7 тэрбум төгрөг буюу 3.7 хувиар дутуу биелсэн бол өмнөх оны мөн үеэс 6,294.3 тэрбум төгрөг буюу 27.0 хувиар нэмэгдсэн байна.

- НТөлөвлөгөөтэй харьцуулахад нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө тайлант хугацаанд 96.3 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.
- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого төлөвлөснөөс 1,122.7 сая төгрөгөөр дутуу биелсэн. Үүнд: Татварын орлого 1.9 хувь буюу 534.7 сая төгрөгөөр, татварын бус орлого 21.0 хувь буюу 588.0 сая төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу биелсэн байна.
- Тайлант хугацаанд орлогын албан татвар, хөрөнгийн албан татвар, онцгой албан татвар, төлөвлөснөөс 1.1-13.5 хувиар давж биелсэн бол нийгмийн даатгалын орлого, нэмэгдсэн өртгийн албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр, хураамж 4.2-7.3 хувиар төлөвлөснөөс дутуу гүйцэтгэлтэй байна.
- Татварын бус орлогын төлөвлөгөө тайлант хугацааны гүйцэтгэлээр 588.0 сая төгрөг буюу 21.0 хувиар дутуу биелсэн нь хувьцааны ногдол ашиг 42.7 сая, газрын тосны орлого 47.1 сая, бусад орлого 526.8 сая төгрөгөөр буюу 16.5-71.1 хувь дутуу биелснээс шалтгаалжээ.

Төсвийн нийт зарлагын хувьд: Нэгдсэн төсвийн нийт зарлага 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр 30,324.3 тэрбум төгрөг болж, 3,248.8 тэрбум төгрөгийн дутуу зарцуулалттай буюу 90.3 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

- Нэгдсэн төсвийн нийт зарлагын гүйцэтгэлийг тайлант хугацааны төлөвлөгөөтэй харьцуулахад 9.7 хувиар дутуу зарцуулагдаж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 34.7 хувиар буюу 7,815.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.
- Зээлийн үйлчилгээний төлбөр өнгөрсөн оны мөн үеэс 45.0 тэрбум төгрөгөөр өссөн бол тайлант хугацааны төлөвлөсөн дүнгээс 27.4 тэрбум төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй гарсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт: Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардалд 2024 онд нийт 3,828.6 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ. 2024 оны эхний урьдчилсан гүйцэтгэлээр 3,093.5 тэрбум төгрөгийг зарцуулж 80.8 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.


МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2024 ОНЫ УРЬДЧИЛСАН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 735.1 тэрбум төгрөгийн алдагдалтай гарчээ.

1. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр 29,589.2 тэрбум төгрөг, нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 17,318.2 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 735.1 тэрбум төгрөгийн алдагдалтай гарчээ. Тайлант хугацаан дахь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл өмнөх оны мөн үеэс 1,521.0 тэрбум төгрөгөөр буурсан бол төлөвлөснөөс 2,126.2 тэрбум төгрөгөөр сайжирсан байна.

График 1. Нэгдсэн төсвийн гүйцэтгэл /тэрбум төгрөгөөр/



Өнгөрсөн оны мөн үеэс нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 27.0 хувь буюу 6,294.3 тэрбум төгрөгөөр, төсвийн нийт зарлага 34.7 хувь буюу 7,815.3 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1,521.0 тэрбум төгрөгөөр буурчээ.

Хүснэгт 1. Нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр

Тэрбум төгрөгөөр

Алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр	ӨО-ны мөн үед	2024 оны урьдчилсан гүйцэтгэл			
		Төл.	Гүйц.	Хувь.	Зөрүү
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-1,028.5	-1,466.1	-3,041.9	207.5	-1,575.9
Засгийн газрын бонд	-704.1	3,005.6	2,985.0	99.3	-20.6
Засгийн газрын зээл	944.2	1,319.1	791.2	60.0	-528.0
Өмч хувьчлал	2.5	2.60	0.84	0.0	-1.76
НИЙТ ДҮН	-785.9	2,861.2	735.1	25.7	-2,126.2

Эх сурвалж: Сангийн яам

2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр гадаад төслийн зээлийн үндсэн төлбөрт 1,232.9 тэрбум төгрөг төлсөн бол 2,024.1 тэрбум төгрөгийн гадаад төслийн зээл шинээр авч, 836.4 сая төгрөгийн өмч хувьчлалын орлогыг төвлөрүүлж, урт хугацаат дотоод бондын үндсэн төлбөрт 137.5 тэрбум төгрөг төлсөн ба гадаад бондын үндсэн төлбөрт 909.9 тэрбум төгрөг төлсөн байна.

2. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого

“ Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 29,589.2 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 27.0 хувь буюу 6,294.3 тэрбум төгрөгөөр, орлогын төлөвлөгөө 3.7 хувь буюу 1,122.7 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн байна.

Нийт тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөөний биелэлтийг төсвийн шатлал бүрээр авч үзвэл улсын төсөв 0.7 хувь буюу 145.9 тэрбум төгрөгөөр, орон нутгийн төсөв 10.8 хувь буюу 861.4 тэрбум төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 2.0 хувь буюу 39.1 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс тус тус дутуу төвлөрчээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 21.4 хувь буюу 338.8 тэрбум төгрөгөөр, улсын төсвийн орлого 24.5 хувь буюу 3,942.7 тэрбум төгрөгөөр, нийгмийн даатгалын сангийн орлого 30.5 хувь буюу 1,302.4 тэрбум төгрөгөөр, орон нутгийн төсвийн орлого 45.8 хувь буюу 2,241.9 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.


Хүснэгт 2. Нэгдсэн төсвийн орлогын 2024 оны урьдчилсан гүйцэтгэл, төсвийн шатлалаар

Тэрбум төгрөгөөр

Ангилал	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС		ЭМДС	
	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	20,652.3	20,471.7	7,994.6	7,133.2	5,893.3	5,574.0	1,964.8	1,925.7
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	478.6	443.9	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	20,173.7	20,027.8	7,994.6	7,133.2	5,893.3	5,574.0	1,964.8	1,925.7
Татварын орлого	16,918.0	17,012.3	5,956.1	5,665.0	4,718.3	4,399.0	1,964.8	1,925.7
Орлогын албан татвар	3,781.4	4,303.9	4,839.5	4,676.6	0.0	0.0	0.0	0.0
Нийгмийн даатгалын орлого	0.0	0.0	0.0	0.0	4,718.3	4,399.0	1,964.8	1,925.7
Хөрөнгийн албан татвар	0.0	0.0	455.3	460.2	0.0	0.0	0.0	0.0
Нэмэгдсэн өртгийн албан татвар	6,220.2	5,864.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Онцгой албан татвар	968.0	1,098.2	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Тусгай зориулалтын орлого	28.0	26.4	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Гадаад үйл ажиллагааны орлого	1,932.5	1,792.4	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бусад татвар, төлбөр, хураамж	3,987.9	3,927.1	661.3	528.2	0.0	0.0	0.0	0.0
Татварын бус орлого	3,255.8	3,015.5	2,038.5	1,468.2	1,175.0	1,175.0	0.0	0.0
Нийтлэг татварын бус орлого	1,098.4	1,171.3	1,131.0	598.5	0.0	0.0	0.0	0.0
Хөрөнгийн орлого	0.0	0.0	16.1	6.6	0.0	0.0	0.0	0.0
Тусламжийн орлого	562.1	428.3	19.8	11.3	1,175.0	1,175.0	0.0	0.0
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,595.3	1,415.9	871.5	851.9	0.0	0.0	0.0	0.0

Эх сурвалж: Сангийн яам

График 2. Нэгдсэн төсвийн орлогын бүтэц /Хувиар/



Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 92.5 хувийг татварын орлого, 7.5 хувийг татварын бус орлого эзэлж байна.

“


Татварын орлого 27,377.4 тэрбум төгрөг болж, орлогын төлөвлөгөө 1.9 хувь буюу 534.7 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн байна.

”

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад татварын орлого 27.4 хувь буюу 5,893.2 тэрбум төгрөгөөр, татварын бус орлого 22.2 хувь буюу 401.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Татварын орлогын 32.8 хувийг орлогын албан татвар, 17.2 хувийг нийгмийн даатгалын орлого, 1.7 хувийг хөрөнгийн албан татвар, 21.4 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 4.0 хувийг онцгой албан татвар, 0.1 хувийг тусгай зориулалтын орлого, 6.5 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 16.3 хувийг бусад татвар, төлбөр, хураамжийн орлого бүрдүүлж байна.

График 3. Татварын орлого /Тэрбум төгрөгөөр/



Тайлант хугацаанд татварын орлого төлөвлөснөөс 1.9 хувь буюу 534.7 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрөхөд нэмэгдсэн өртгийн албан татвар 5.7 хувиар (355.9 тэрбум төгрөг), гадаад үйл ажиллагааны орлого 7.3 хувиар (140.2 тэрбум төгрөг), тусгай зориулалтын орлого 5.6 хувиар (1.6 тэрбум төгрөг) тус тус төлөвлөснөөс дутуу биелсэн нь нөлөөлжээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр татварын орлого 27.4 хувь буюу 5,893.2 тэрбум төгрөгөөр өсөхөд орлогын албан татвар 57.5 хувь (3,277.9 тэрбум төгрөг)-аар, нийгмийн даатгалын орлого 19.0 хувь (749.2 тэрбум төгрөг), хөрөнгийн албан татвар 16.6 хувь (65.4 тэрбум төгрөг), нэмэгдсэн өртгийн албан татвар 22.8 хувь (1,087.4 тэрбум төгрөг), гадаад үйл ажиллагааны орлого 22.3 хувь (327.0 тэрбум төгрөг) -аар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.




Татварын бус орлого 2,211.8 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 401.1 тэрбум төгрөгөөр өссөн бол төлөвлөснөөс 588.0 тэрбум төгрөг буюу 21.0 хувиар дутуу төвлөжээ.



Төлөвлөгөөтэй харьцуулахад төсөвт байгууллагын өөрийн орлого 178.3 тэрбум төгрөгөөр, хүүгийн орлого 4.3 тэрбум төгрөгөөр тус тус давж биелжээ.

Харин торгуулийн орлого 5.3 тэрбум төгрөгөөр, төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого 9.6 тэрбум төгрөг, хувьцааны ноогдол ашиг 42.7 тэрбум төгрөгөөр, тусламжийн орлого 142.4 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу төвлөрсөн байна.

График 4. Татварын бус орлогын бүтэц /Хувиар/



Татварын бус орлогын 80.0 хувийг нийтлэг татварын бус орлого, 19.7 хувийг тусламжийн орлого, 0.3 хувийг хөрөнгийн орлого эзэлж байна. .

Нийтлэг татварын бус орлогыг бүрдүүлэгч эх үүсвэрүүдийг бүтцийн хувьд авч үзвэл 11.0 хувийг хүүгийн орлого, 11.1 хувийг торгуулийн орлого, 13.4 хувийг газрын тосны орлого, 36.5 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого, 0.5 хувийг түрээсийн орлого, 4.5 хувийг навигацийн орлого эзэлсэн бол 12.1 хувийг бусад орлого бүрдүүлж байна.



Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн нийт зарлага 5,952.3 тэрбум төгрөг буюу 31.7 хувиар нэмэгдэж 24,704.4 тэрбум төгрөг зарцуулагдсан байна.



3. Нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээл

Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлд 33,573.1 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсний 90.3 хувийг зарлагдаж 3,248.8 тэрбум төгрөгийг дутуу зарцуулжээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн нийт зарлага 7,815.3 тэрбум төгрөг буюу 34.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 4. Нэгдсэн төсвийн зарлагын 2024 оны урьдчилсан гүйцэтгэл /төсвийн шатлалаар/

Тэрбум төгрөгөөр

Зардлын зүйл	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС		ЭМДС	
	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	22,677.8	21,161.0	9,239.4	7,212.9	5,122.2	5,095.0	1,848.2	1,926.9
НИЙТ ЗАРЛАГА	22,574.7	20,901.7	9,080.4	7,090.8	5,189.5	5,097.5	1,933.2	1,931.3
УРСГАЛ ЗАРДАЛ	16,467.7	15,866.1	4,801.2	4,202.1	5,189.5	5,097.5	1,933.2	1,931.3
Бараа, ажил, үйлчилгээний зардал	8,028.9	7,723.2	2,569.9	2,208.5	1.1	2.6	69.6	14.8
Зээлийн үйлчилгээний төлбөр	1,173.6	1,124.9	72.4	70.1	0.0	0.0	0.0	0.0
Татаас	1,841.6	1,776.1	355.9	353.4	0.0	0.0	0.0	0.0
Урсгал шилжүүлэг	5,423.5	5,241.8	1,803.0	1,570.0	5,188.4	5,095.0	1,863.6	1,916.6
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,107.0	5,035.6	4,279.2	2,888.8	0.0	0.0	0.0	0.0
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	103.1	259.2	159.0	122.1	-67.2	-2.5	-85.0	-4.4
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-2,504.1	-1,133.1	-1,244.8	-79.7	771.0	479.0	116.6	-1.3

Эх сурвалж: Сангийн яам

Улсын төсвийн зарлага тайлант хугацаанд төлөвлөснөөс 1,516.9 тэрбум, орон нутгийн төсвийн зарлага 2,026.5 тэрбум, нийгмийн даатгалын сангийн зарлага 27.2 тэрбум төгрөгөөр тус тус дутуу зарцуулагджээ.

Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн өнгөрсөн оны мөн үеэс 34.7 хувь буюу 7,815.3 тэрбум төгрөгөөр өсөхөд урсгал зардал 4,934.1 тэрбум, хөрөнгийн зардал 2,736.2 тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлжээ.



Зээлийн үйлчилгээний төлбөр өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 45.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бол тайлант хугацааны төлөвлөсөн дүнгээс 2.2 хувь буюу 27.4 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулалттай гарсан байна.



Хүснэгт 5. Нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн гүйцэтгэл /зардлын эдийн засгийн ангиллаар/

Тэрбум төгрөгөөр

ҮЗҮҮЛЭЛТ	ӨО-ны мөн үе	2024 оны урьдчилсан гүйцэтгэл			
		Төл.	Гүйц.	Хувь	Зөрүү
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	22,509.0	33,573.1	30,324.3	-9.7	-3,248.8
НИЙТ ЗАРЛАГА	22,279.6	33,463.2	29,949.9	-10.5	-3,513.3
УРСГАЛ ЗАРДАЛ	17,091.4	23,077.0	22,025.5	-4.6	-1,051.5
БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,085.4	10,104.0	9,404.1	-6.9	-699.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,327.5	5,553.6	5,363.4	-3.4	-190.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	388.8	556.9	498.2	-10.5	-58.7
Хангамж, бараа материалын зардал	206.3	340.6	320.6	-5.9	-20.0
Нормативт зардал	226.6	344.8	321.0	-6.9	-23.8
Эд хогшил, урсгал засварын зардал	159.8	239.7	244.0	1.8	4.3
Томилолт, зочны зардал	49.2	91.0	75.7	-16.9	-15.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,018.1	1,562.1	1,372.4	-12.1	-189.7
Бараа үйлчилгээний бусад зардал	709.1	1,415.3	1,208.9	-14.6	-206.4
ХҮҮ	1,150.0	1,222.4	1,195.0	-2.2	-27.4
ТАТААС	579.7	1,022.6	954.5	-6.7	-68.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,276.3	10,728.0	10,471.8	-2.4	-256.1
Засгийн газрын урсгал шилжүүлэг	3,595.1	2,253.5	2,251.5	-23.7	-2,461.9
Бусад урсгал шилжүүлэг	6,681.3	8,474.5	8,220.3	3.1	264.5
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,188.2	10,386.3	7,924.4	-23.7	-2,461.9
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	229.4	109.9	374.4	240.7	264.5

Эх сурвалж: Сангийн яам


“ Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнд урсгал зардлын эзлэх хувийн жин 72.6 хувь болж, өнгөрсөн оны мөн үеэс 3.3 пунктээр буурсан байна.

Нэгдсэн төсвийн нийт зарлагын 72.6 хувь буюу 22,025.5 тэрбум төгрөг нь урсгал зардал бөгөөд нийт урсгал зардлын 47.5 хувийг урсгал шилжүүлэг, 42.7 хувийг бараа, ажил үйлчилгээний зардал, 24.4 хувийг цалин хөлсний зардал, 5.4 хувийг зээлийн үйлчилгээний төлбөр, 6.2 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, 4.3 хувийг татаас тус тус эзэлж байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн урсгал зардал 4,934.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд: бараа, ажил үйлчилгээний зардал 4,318.7 тэрбум төгрөгөөр, цалин хөлс болон нэмэгдэл урамшил 3,035.9 тэрбум төгрөгөөр, урсгал шилжүүлэг 195.5 тэрбум төгрөгөөр, зээлийн үйлчилгээний төлбөр 45.0 тэрбум төгрөгөөр, татаас 374.9 тэрбум төгрөгөөр, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 145.0 тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

График 5. Урсгал зардлын бүтэц /Хувиар/

“ Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар 39 төсвийн ерөнхийлөн захирагчдын төсөв зарцуулах эрхийг баталсан бөгөөд 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр нийт зарлага 1,494.2 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдаж 93.4 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.



” Төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт зарлагын 16.0 хувийг Сангийн сайдын багц, 13.0 хувийг Боловсролын сайдын багц, 12.8 хувийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багц, 5.1 хувийг Эрүүл мэндийн сайдын багц, 4.6 хувийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын багц, үлдэх 48.6 хувийг бусад төсвийн ерөнхийлөн захирагчдын зардал эзэлж байна.

Хүснэгт 6. Улсын төсвийн нийт зардал, төсвийн ерөнхийлөн захирагчаар

Сая төгрөгөөр

Төсвийн ерөнхийлөн захирагч	2024 оны урьдчилсан гүйцэтгэл			
	Төл.	Гүйц.	Зөрүү	Хувь
Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга	30,283.9	28,870.8	-1,413.11	95.3
Монгол Улсын Их Хурлын дарга	142,182.7	120,339.9	-21,842.78	84.6
Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга	4,510.2	4,507.2	-3.04	99.9
Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч	29,070.1	27,274.1	-1,795.96	93.8
Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга	171,153.6	156,925.5	-14,228.05	91.7
Улсын ерөнхий прокурор	110,621.1	101,924.5	-8,696.64	92.1
Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга	18,849.9	18,843.5	-6.35	100.0
Монгол Улсын Ерөнхий сайд	384,831.7	339,015.8	-45,815.95	88.1
Монгол Улсын Шадар сайд /онцгой байдлын асуудал эрхэлсэн/	363,931.8	360,761.0	-3,170.85	99.1
Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	238,099.9	109,625.0	-128,474.81	46.0
Сангийн сайд	5,212,070.1	4,837,561.2	-374,508.91	92.8
Хууль зүй, дотоод хэргийн сайд	1,386,123.7	1,387,330.6	1,206.95	100.1
Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд	240,267.2	224,358.7	-15,908.54	93.4
Батлан хамгаалахын сайд	613,066.5	608,358.3	-4,708.22	99.2
Боловсролын сайд	4,151,509.0	3,947,417.6	-204,091.31	95.1
Гадаад харилцааны сайд	207,047.1	146,717.5	-60,329.55	70.9
Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд	61,794.3	59,248.0	-2,546.35	95.9
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	716,016.6	685,562.2	-30,454.39	95.7
Эрүүл мэндийн сайд	1,658,681.7	1,553,461.2	-105,220.48	93.7
Төрийн албаны зөвлөлийн дарга	7,554.9	6,660.3	-894.57	88.2
Сонгуулийн ерөнхий хорооны дарга	73,210.6	68,970.7	-4,239.86	94.2
Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга	5,571.7	5,571.6	-0.13	100.0
Монгол Улсын Ерөнхий аудитор	44,294.5	42,689.3	-1,605.24	96.4
Санхүүгийн зохицуулах хорооны дарга	14,727.6	11,692.0	-3,035.59	79.4
Үндэсний статистикийн хорооны дарга	21,784.5	21,393.6	-390.92	98.2
Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комиссын дарга	8,314.6	8,290.5	-24.03	99.7
Зам, тээврийн сайд	817,916.9	710,771.2	-107,145.77	86.9
Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд	463,888.7	379,280.0	-84,608.74	81.8
Эрчим хүчний сайд	468,184.1	443,613.3	-24,570.86	94.8
Авлигатай тэмцэх газрын дарга	48,006.0	45,744.7	-2,261.29	95.3
Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд	575,318.0	500,069.5	-75,248.50	86.9
Монгол Улсын Шадар сайд /өрсөлдөөний асуудал эрхэлсэн/	5,143.1	4,396.9	-746.17	85.5
Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	3,943,704.6	3,869,411.7	-74,292.93	98.1
Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний үндэсний хорооны дарга	14,506.6	10,304.2	-4,202.36	71.0
Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга	116,229.2	87,931.2	-28,297.97	75.7
Шүүхийн сахилгын хорооны дарга	4,862.1	4,769.8	-92.27	98.1
Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд, Эдийн засаг, хөгжлийн сайд	183,147.5	144,131.3	-39,016.22	78.7
Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд	87,490.3	67,037.6	-20,452.73	76.6
Монгол Улсын сайд, боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга	11,176.3	10,124.9	-1,051.47	90.6
НИЙТ ЗАРДАЛ	22,655,143.0	21,160,957.0	-1,494,185.99	93.4

Эх сурвалж: Сангийн яам

2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр 3,093.5 тэрбум төгрөгийг зарцуулж 80.8 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

4. Улсын төсвийн хөрөнгө оруулалт

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардалд 2024 онд нийт 3,828.6 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ. 2024 оны эхний урьдчилсан гүйцэтгэлээр 3,093.5 тэрбум төгрөгийг зарцуулж 80.8 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

Хүснэгт 7. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэл
/Төсвийн ерөнхийлөн захирагчаар/


Сая төгрөгөөр

Хуулийн дугаар	ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ	2024 оны төсөв	2024 оны урьдчилсан гүйцэтгэл			
			Төл.	Гүйц.	Зөрүү	Хувь
I	МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА	22,089.6	22,089.6	21,406.4	683.2	96.9
II	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	1,200.0	1,200.0	1,060.0	140.0	88.3
III	МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД	67,465.9	67,465.9	57,184.5	10,281.3	84.8
IV	МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	89,687.7	89,687.7	89,205.5	482.1	99.5
V	МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	155,351.5	155,351.5	43,807.8	111,543.7	28.2
VI	МОНГОЛ УЛСЫН САЙД, 20 МИНУТЫН ХОТ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА	116,229.2	116,229.2	87,931.2	28,298.0	75.7
VII	МОНГОЛ УЛСЫН САЙД, БООМТЫН СЭРГЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА	5,463.1	5,463.1	5,460.1	3.0	99.9
VIII	ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД	13,700.0	13,700.0	13,381.3	318.7	97.7
IX	САНГИЙН САЙД	293,606.2	293,606.2	277,144.4	16,461.8	94.4
X	ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	127,187.7	127,187.7	121,188.1	5,999.6	95.3
XI	БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	55,780.7	55,780.7	55,637.4	143.3	99.7
XII	БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД	20,537.7	20,537.7	18,389.8	2,147.9	89.5
XIII	БОЛОВСРОЛЫН САЙД	723,054.9	723,054.9	546,890.7	176,164.2	75.6
XIV	ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	48,758.1	48,758.1	35,465.3	13,292.8	72.7
XV	ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД	737,123.5	737,123.5	635,473.0	101,650.5	86.2
XVI	СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН САЙД	244,691.4	244,691.4	180,375.3	64,316.1	73.7
XVII	ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙД	413,783.0	413,783.0	349,794.8	63,988.2	84.5
XVIII	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	120,533.8	120,533.8	105,197.2	15,336.5	87.3
XIX	ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД	16,423.0	16,423.0	5,288.1	11,135.0	32.2
XX	ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	226,014.0	226,014.0	203,306.6	22,707.4	90.0
XXI	ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	282,639.0	282,639.0	199,170.3	83,468.7	70.5
XXII	АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА	2,658.2	2,658.2	2,448.7	209.5	92.1
XXIII	УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ	11,528.8	11,528.8	10,969.9	558.9	95.2
XXIV	ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	19,975.0	19,975.0	14,694.0	5,281.0	73.6
XXV	УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	11,348.3	11,348.3	11,043.4	304.9	97.3
XXVI	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР	881.1	881.1	763.7	117.4	86.7
XXVII	САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА	892.5	892.5	823.2	69.3	92.2
	НИЙТ	3,828,603.7	3,828,603.6	3,093,500.6	735,103.0	80.8



Эх сурвалж: Сангийн яам

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА

/Тэрбум төгрөгөөр/



НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН




↑ -Өөрчлөлт (Өнгөрсөн оны мөн үеэс)

Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтэс

Нийгмийн даатгалын сангийн зарлагад 5,095.0 тэрбум төгрөгийг зарцуулсан нь өнгөрсөн оны мөн үеэс 1,060.1 тэрбум төгрөг буюу 26.3 хувиар өссөн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад тэтгэврийн даатгалын сангийн зарлага 994.1 тэрбум төгрөгөөр, тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 41.2 тэрбум төгрөгөөр, ҮОМШӨ-ий даатгалын сангийн зарлага 293.3 тэрбум төгрөгөөр, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 26.0 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр нийгмийн даатгалын санд нийт 5,574.0 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь төлөвлөснөөс 5.4 хувь буюу 319.3 тэрбум төгрөгөөр дутуу биелэн орлогын гүйцэтгэл 94.6 хувьтай гарсан байна.


График 6. Нийгмийн даатгалын сангийн нийт зарлагын бүтэц /Хувиар/



6. Эрүүл мэндийн даатгалын сан

“ Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 2.0 хувиар дутуу биелжээ. ”


График 7. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого /Тэрбум төгрөгөөр/



Эрүүл мэндийн даатгалын санд 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр 1,925.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь төлөвлөснөөс 2.0 хувь буюу 39.1 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн байна.

“ Эрүүл мэндийн даатгалын сангаас 1,926.9 тэрбум төгрөгийн зарлага хийгдэж өнгөрсөн оны мөн үеэс 328.9 тэрбум төгрөгөөр өссөн байна. ”

График 8. Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага /Тэрбум төгрөгөөр/



2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 1,848.2 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөж, 1,926.9 тэрбум төгрөгийг зарцуулж, тус сангийн гүйцэтгэл 104.3 хувьтай гарчээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад тус сангийн нийт зарлага 328.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.

2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн зарлага 2,026.5 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.

7. Орон нутгийн төсөв

2024 Тайлант хугацаанд орон нутгийн төсвийн орлого 7,133.2 тэрбум төгрөг болж төлөвлөсөн дүнгээс 10.8 хувь буюу 861.4 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн бол орон нутгийн төсвийн нийт зарлага 7,212.9 тэрбум төгрөг болж төлөвлөснөөс 21.9 хувь буюу 2,026.5 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдаж, орон нутгийн төсвийн тэнцэл 79.7 тэрбум төгрөгийн алдагдалтай гарчээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад орон нутгийн төсвийн орлого 45.8 хувиар буюу 2,241.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бол, орон нутгийн төсвийн нийт зарлага 66.3 хувь буюу 2,876.6 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Орон нутгийн төсвийн нийт орлогын 88.1 хувийг орон нутгийн төсвийн орлого, 5.2 хувийг улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, 6.8 хувийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлэг тус тус эзэлж байна. Улсын төсвөөс орон нутгийн төсөвт 368.0 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгохоор төлөвлөгдөж 100 хувийн гүйцэтгэлтэй, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлэгт 503.5 тэрбум төгрөгийг шилжүүлэхээр төлөвлөгдөж 96.1 хувийн гүйцэтгэлтэй тус тус гарсан байна.

Хүснэгт 8. Аймгуудад улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлэг


Сая төгрөгөөр

АЙМАГ	САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ			ОН-ИЙН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН САНГИЙН ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛЭГ		
	Олгох	Олгосон	Хувь	Олгох	Олгосон	Хувь
Архангай	33,831.9	33,831.9	100.0	12,690.8	12,186.4	96
Баян-Өлгий	22,080.6	22,080.6	100.0	11,949.5	11,467.1	96
Баянхонгор	34,182.5	34,182.5	100.0	21,577.0	20,790.0	96.4
Булган	10,232.3	10,232.3	100.0	14,228.4	13,675.4	96.1
Говь-Алтай	26,065.0	26,065.0	100.0	17,357.4	16,596.2	95.6
Дорноговь	-	-	0.0	42,708.1	40,852.2	95.7
Дорнод	-	-	0.0	25,422.0	24,115.2	94.9
Дундговь	18,195.6	18,195.6	100.0	15,880.4	15,334.9	96.6
Завхан	37,581.9	37,581.9	100.0	14,700.7	14,095.3	95.9
Өвөрхангай	27,680.8	27,680.8	100.0	14,480.8	13,880.1	95.9
Өмнөговь	-	-	0.0	47,716.0	46,025.8	96.5
Сүхбаатар	13,917.6	13,917.6	100.0	18,215.7	17,515.4	96.2
Сэлэнгэ	-	-	0.0	27,768.4	26,784.6	96.5
Төв	16,840.6	16,840.6	100.0	28,366.8	27,395.6	96.6
Увс	30,877.0	30,877.0	100.0	13,069.0	12,546.3	96
Ховд	12,982.1	12,982.1	100.0	29,385.2	28,327.4	96.4
Хөвсгөл	37,957.8	37,957.8	100.0	16,739.1	16,065.8	96
Хэнтий	38,777.6	38,777.6	100.0	18,587.1	17,914.6	96.4
Дархан-Уул	-	-	0.0	20,763.4	20,023.7	96.4
Улаанбаатар	-	-	0.0	50,167.0	48,042.6	95.8
Орхон	-	-	0.0	34,710.3	33,480.2	96.5
Говьсүмбэр	6,836.4	6,836.4	100.0	7,000.3	6,740.7	96.3
ДҮН	368,039.7	368,039.7	100.0	503,483.6	483,855.4	96.1

Эх сурвалж: Сангийн яам

Орон нутгийн нийт орлого төлөвлөснөөс 861.4 тэрбум төгрөг буюу 10.8 хувиар дутуу төвлөрсөн нь орон нутгийн татварын орлого 4.9 хувь буюу 291.1 тэрбум, татварын бус орлого 28.0 хувь буюу 570.3 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөнтэй холбоотой байна.

График 9. Орон нутгийн төсвийн орлогын бүтэц /Хувиар/



Орон нутгийн орлогыг аймгуудаар харуулбал: Хөвсгөл аймаг 24,018.0 сая, Дундговь аймаг 17,289.7 сая, Хэнтий аймаг 14,285.0 сая, Дархан-Уул аймаг 13,879.7 сая, Ховд аймаг 9,003.1 сая, Өвөрхангай аймаг 9,078.2 сая, Төв аймаг 8,632.3 сая, Завхан аймаг 8,593.4 сая, Булган аймаг 6,318.0 сая, Архангай аймаг 6,690.0 сая, Увс аймаг 6,331.5 сая, Дорнод аймаг 4,733.7 сая, Говьсүмбэр аймаг 3,592.3 сая төгрөгөөр төлөвлөгөөг давуулан биелүүлсэн бол Өмнөговь аймаг 200,347.2 сая, Дорноговь аймаг 32,583.0 сая, Сүхбаатар аймаг 9,389.7 сая, Орхон аймаг 37,880.2 сая, Сэлэнгэ аймаг 425.3 сая, Говь-Алтай аймаг 5,680.9 сая, Баян-Өлгий аймаг 3,890.1 сая, Улаанбаатар хот 686,535.8 сая төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу төвлөрүүлсэн байна.